



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/180/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2026.02.25</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: Munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: Adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудит хийгдээгүй болно. ....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МАЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОУБ	Олон улсын байгууллага
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлгийн ариун цэврийн төв лаборатори
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2026.02.24 № 2/62

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 45 дугаар тогтоолоор Мал эмнэлгийн лабораторийн барилгыг акталж, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлээс хассан байна. Үүнтэй холбоотойгоор лабораторийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад эрсдэл үүсэж, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтыг хангах зорилгоор лабораторийн барилгын халаалтын зардалд нийт 26.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

**6426050186**

/2026 он/1. бичиг хэрэг/тоот/2. а4-  
албан тоот.docx

Тайлант онд улсын болон орон нутгийн төсвөөс 960.2 сая төгрөгийн санхүүжилт дутуу орж ирсэн болон санхүүжилтийг хуваарийн дагуу олгоогүй татсанаас 972.9 сая төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудал**

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭВГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>256,508,939.71</b>	<b>1,210,887,375.33</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>1,100,000.00</b>	<b>970,555,112.05</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	6,596,742.05
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	2,681,500.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>1,100,000.00</b>	<b>961,276,870.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	1,100,000.00	961,276,870.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>255,408,939.71</b>	<b>240,332,263.28</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>206,846,557.06</b>	<b>176,238,085.33</b>
35110	Тусгай зориулалттай материал	125,606,166.25	109,867,169.69
35130	Эм боох материал	81,240,390.81	66,370,915.64
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>46,972,382.65</b>	<b>62,944,177.95</b>
35410	Бичиг хэргийн материал	7,443,955.00	8,254,485.10
35420	Аж ахуйн материал	25,840,481.33	49,689,337.33
35430	Сэлбэг хэрэгсэл	-	875,600.00
35440	Түлш, шатах тослох материал	2,172,461.32	59,455.52
35470	Бусад хангамжийн материал	11,515,485.00	4,065,300.00
35600	Мал амьтад	1,590,000.00	1,150,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,581,863,355.36</b>	<b>1,429,461,416.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,581,863,355.36</b>	<b>1,429,461,416.31</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,441,539,605.30</b>	<b>1,289,137,666.25</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	64,691,600.00	32,804,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,474,659.04)	(24,018,818.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,505,612,000.00	1,505,612,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(412,902,842.61)	(634,488,466.85)
39205	Машин тоног төхөөрөмж	1,000,360,234.15	875,279,864.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(691,963,740.85)	(494,449,307.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,634,200.00	67,029,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,417,186.35)	(38,631,804.40)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>140,323,750.06</b>	<b>140,323,750.06</b>
39301	Програм хангамж	2,280,000.00	2,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(981,249.94)	(981,249.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	139,025,000.00	139,025,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,838,372,295.07</b>	<b>2,640,348,791.64</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,157,951.59</b>	<b>972,889,832.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,157,951.59</b>	<b>972,889,832.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>1,157,951.59</b>	<b>972,889,832.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,157,951.59	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	(0.00)	157,472,782.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>-</b>	<b>815,417,050.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	815,417,050.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,837,214,343.48</b>	<b>1,667,458,959.64</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,837,214,343.48</b>	<b>1,667,458,959.64</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	139,025,000.00	139,025,000.00
51101	Өмч: - төрийн	139,025,000.00	139,025,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,643,511,693.41</b>	<b>1,500,051,659.64</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,937,947,293.35	1,669,807,043.48
51220	Тайлант үеийн үр дүн	(294,435,599.94)	(169,755,383.84)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	54,677,650.07	28,382,300.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,838,372,295.07</b>	<b>2,640,348,791.64</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,319,828,409.62</b>	<b>4,706,740,307.48</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>733,247,232.62</b>	<b>1,126,387,244.98</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	733,247,232.62	1,126,387,244.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,164,750.00	5,181,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,164,750.00	5,181,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	28,572,200.00	254,926,062.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	701,510,282.62	866,279,682.98
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,586,581,177.00</b>	<b>3,580,353,062.50</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,998,750,476.00	1,978,563,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,998,750,476.00	1,978,563,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,587,830,701.00	1,601,789,162.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	844,431,550.00	1,054,124,662.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	741,980,050.00	547,664,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,419,101.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,614,264,009.56</b>	<b>4,876,495,691.32</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,614,264,009.56</b>	<b>4,876,495,691.32</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,387,886,369.06</b>	<b>4,814,433,488.18</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,338,349,736.65	1,588,932,004.58
210101	Үндсэн цалин	734,636,120.15	920,973,343.39
210102	Нэмэгдэл	452,191,055.50	516,886,645.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,191,800.00	81,487,952.00
210104	Урамшуулал	79,330,761.00	69,584,063.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	164,234,444.50	205,022,788.29
210201	Тэтгэврийн даатгал	111,526,144.50	141,849,371.49
210202	Тэтгэмжийн даатгал	13,177,000.00	15,601,311.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,588,600.00	8,896,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,588,600.00	7,706,005.70
210205	Эрүүл мэндийн даатгал	26,354,100.00	30,969,499.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	39,792,624.94	41,304,042.85
210301	Гэрэл, цахилгаан	1,947,333.02	3,876,974.05
210302	Түлш, халаалт	36,201,099.92	26,168,192.80
210303	Цэвэр, бохир ус	1,644,192.00	3,758,876.00
210304	Байрны түрээс	-	7,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	57,330,503.02	40,939,148.18
210401	Бичиг хэрэг	5,596,100.00	5,679,100.00
210402	Тээвэр, шатахуун	42,909,923.02	21,254,742.18
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,778,680.00	3,768,345.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,845,800.00	9,236,961.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,038,586,728.26	1,483,600,865.67
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,038,586,728.26	1,483,600,865.67
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,228,900.00	-
210604	Урсгал засвар	22,228,900.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	32,017,000.00	11,456,000.00
210702	Дотоод албан томилолт	32,017,000.00	11,456,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,314,276,668.00	991,597,110.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,303,471,528.00	984,178,680.00

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	-	1,759,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,796,040.00	1,661,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	528,000.00	781,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,925,000.00	660,000.00
210807	Газрын төлбөр	556,100.00	556,100.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	-	2,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>381,069,763.69</b>	<b>451,581,528.61</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	37,933,527.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	264,900.00	120,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	380,604,863.69	413,528,001.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>226,377,640.50</b>	<b>62,062,203.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>218,810,153.00</b>	<b>40,139,224.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,175,776.00	22,469,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	183,634,377.00	16,110,324.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	1,559,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,567,487.50</b>	<b>21,922,979.14</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,196,311.50	21,922,979.14
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	371,176.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(294,435,599.94)</b>	<b>(169,755,383.84)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(294,435,599.94)</b>	<b>(169,755,383.84)</b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,589,745,927.00</b>	<b>3,585,534,562.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,164,750.00</b>	<b>5,181,500.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,164,750.00	5,181,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,164,750.00	5,181,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,164,750.00	5,181,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>3,586,581,177.00</b>	<b>3,580,353,062.50</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,998,750,476.00	1,978,563,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,998,750,476.00	1,978,563,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,587,830,701.00	1,601,789,162.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	844,431,550.00	1,054,124,662.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	741,980,050.00	547,664,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,419,101.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>3,564,204,127.00</b>	<b>3,581,534,562.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,564,204,127.00</b>	<b>3,581,534,562.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,337,826,486.50</b>	<b>3,516,790,859.36</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,337,191,785.06	1,597,832,842.29
210101	Үндсэн цалин	733,478,168.56	929,874,181.10
210102	Нэмэгдэл	452,191,055.50	516,886,645.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,191,800.00	81,487,952.00
210104	Урамшуулал	79,330,761.00	69,584,063.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>164,234,444.50</b>	<b>203,876,644.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	111,526,144.50	140,703,227.44

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	13,177,000.00	15,601,311.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,588,600.00	8,896,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	6,588,600.00	7,706,005.70
210205	Эрүүл мэндийн даатгал	26,354,100.00	30,969,499.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>39,792,624.94</b>	<b>41,304,042.85</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,947,333.02	3,876,974.05
210302	Түлш, халаалт	36,201,099.92	26,168,192.80
210303	Цэвэр, бохир ус	1,644,192.00	3,758,876.00
210304	Байрны түрээс	-	7,500,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>28,085,480.00</b>	<b>20,136,100.00</b>
210401	Бичиг хэрэг	5,747,100.00	2,994,800.00
210402	Тээвэр, шатахуун	13,713,400.00	11,161,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,778,680.00	2,693,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,646,300.00	2,287,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,693,584.00</b>	<b>4,111,800.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,693,584.00	4,111,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,029,500.00</b>	<b>29,765,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	140,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	20,000,000.00
210604	Урсгал засвар	22,889,500.00	9,765,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>32,017,000.00</b>	<b>11,456,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	32,017,000.00	11,456,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,695,517,168.00</b>	<b>1,608,188,130.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,684,592,028.00	1,602,785,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,759,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,796,040.00	1,661,980.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	528,000.00	781,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,045,000.00	660,000.00
210807	Газрын төлбөр	556,100.00	540,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>264,900.00</b>	<b>120,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	264,900.00	120,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>226,377,640.50</b>	<b>64,743,703.14</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>218,810,153.00</b>	<b>40,139,224.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,175,776.00	22,469,900.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	183,634,377.00	16,110,324.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000,000.00	1,559,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,567,487.50</b>	<b>24,604,479.14</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,196,311.50	24,604,479.14
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	371,176.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>25,541,800.00</b>	<b>4,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>25,541,800.00</b>	<b>4,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>25,541,800.00</b>	<b>4,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>25,541,800.00</b>	<b>4,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,541,800.00	4,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(25,541,800.00)</b>	<b>(4,000,000.00)</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
						C01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	139,025,000.00	54,677,650.07	1,937,947,293.35	0.00	2,131,649,943.42
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-294,435,599.94	0.00	-294,435,599.94
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	139,025,000.00	54,677,650.07	1,643,511,693.41	0.00	1,837,214,343.48
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	139,025,000.00	54,677,650.07	1,643,511,693.41	0.00	1,837,214,343.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	26,295,350.07	0.00	26,295,350.07
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	139,025,000.00	54,677,650.07	1,669,807,043.48	0.00	1,863,509,693.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-26,295,350.07	0.00	0.00	-26,295,350.07
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-169,755,383.84	0.00	-169,755,383.84
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	139,025,000.00	28,382,300.00	1,500,051,659.64	0.00	1,667,458,959.64

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>				
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,113,283,200.00	1,959,140,920.86	154,142,279.14	92.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,110,783,200.00	1,953,959,420.86	156,823,779.14	92.6
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2,500,000.00	5,181,500.00	-2,681,500.00	207.3
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	5,181,500.00	-2,681,500.00	207.3
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,113,283,200.00	1,959,140,920.86	154,142,279.14	92.7
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,113,283,200.00	1,959,140,920.86	154,142,279.14	92.7
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,065,221,300.00	1,919,001,696.86	146,219,603.14	92.9
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,590,299,900.00	1,576,210,229.79	14,089,670.21	99.1
210101	Үндсэн цалин	956,151,500.00	929,874,181.10	26,277,318.90	97.3
210102	Нэмэгдэл	476,903,700.00	495,264,033.22	-18,360,333.22	103.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	72,741,100.00	81,487,952.00	-8,746,852.00	112.0
210104	Урамшуулал	84,503,600.00	69,584,063.47	14,919,536.53	82.3

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	203,844,400.00	203,645,794.22	198,605.78	99.9
210201	Тэтгэврийн даатгал	140,559,800.00	140,472,377.44	87,422.56	99.9
210202	Тэтгэмжийн даатгал	15,607,100.00	15,601,311.28	5,788.72	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,900,600.00	8,896,600.00	4,000.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	7,707,400.00	7,706,005.70	1,394.30	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	31,069,500.00	30,969,499.80	100,000.20	99.7
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,351,000.00	41,304,042.85	46,957.15	99.9
210301	Гэрэл, цахилгаан	3,770,100.00	3,876,974.05	-106,874.05	102.8
210302	Түлш, халаалт	27,832,700.00	26,168,192.80	1,664,507.20	94.0
210303	Цэвэр, бохир ус	748,200.00	3,758,876.00	-3,010,676.00	502.4
210304	Байрны түрээс	9,000,000.00	7,500,000.00	1,500,000.00	83.3
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,216,100.00	20,136,100.00	80,000.00	99.6
210401	Бичиг хэрэг	2,994,800.00	2,994,800.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	11,161,200.00	11,161,200.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,693,100.00	2,693,100.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	1,000,000.00	80,000.00	92.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,287,000.00	2,287,000.00	0.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,884,500.00	4,111,800.00	772,700.00	84.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,624,800.00	4,111,800.00	513,000.00	88.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	259,700.00	0.00	259,700.00	0.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	34,192,900.00	33,765,300.00	427,600.00	98.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	14,192,900.00	13,765,300.00	427,600.00	97.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	11,620,000.00	11,456,000.00	164,000.00	98.6
210702	Дотоод албан томилолт	11,620,000.00	11,456,000.00	164,000.00	98.6
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	158,442,500.00	28,252,430.00	130,190,070.00	17.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	147,969,300.00	22,850,100.00	125,119,200.00	15.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	447,900.00	0.00	447,900.00	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,759,350.00	40,650.00	97.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,674,500.00	1,661,980.00	12,520.00	99.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	910,800.00	781,000.00	129,800.00	85.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,100,000.00	660,000.00	4,440,000.00	12.9
210807	Газрын төлбөр	540,000.00	540,000.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	370,000.00	120,000.00	250,000.00	32.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	370,000.00	120,000.00	250,000.00	32.4
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	48,061,900.00	40,139,224.00	7,922,676.00	83.5
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	48,061,900.00	40,139,224.00	7,922,676.00	83.5
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,469,900.00	22,469,900.00	0.00	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	23,592,000.00	16,110,324.00	7,481,676.00	68.3

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,559,000.00	441,000.00	78.0
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	53	53	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	50	50	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	43	43	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	0	100.0

## 2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл /төгрөгөөр/
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,601,789,162.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,601,789,162.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,601,789,162.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>21,622,612.50</b>
210102	Нэмэгдэл	21,622,612.50
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>230,850.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	230,850.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,579,935,700.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,579,935,700.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,601,789,162.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,601,789,162.50</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,054,124,662.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	547,664,500.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах замаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус байгууллага нь 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн тайланд 4 зорилтын хүрээнд 40 арга хэмжээ төлөвлөж биелэлт 100 хувь гэж тайлагнасан ба гүйцэтгэлийн үнэлгээ баталгаажиж ирээгүй байна.

Тайлант онд мал аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд 48 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй хамтран мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах анхан шатны үйлчилгээг ард иргэдэд үзүүлж, УМЭАЦТЛ-той Vetlab.shinjilee.mn цахим системээр дээж бүртгэн нийт 428 дүнгийн хуудас гаргаж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын дотоод аудит/аудиторын чиг үүргийг байгууллагын даргын 2021 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/23 тушаалаар баталсан “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын дагуу дотоод хяналтын баг хэрэгжүүлдэг ба дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад холбогдох хууль, журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллага нь 2022 онд батлагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг ба нягтлан бодох бүртгэлийн онцлогт нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайланг “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 801,976.5 мянган төгрөгөөр буюу 1.4 дахин өссөн байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,100.00	970,555.11	969,455.11
Бараа материал	255,408.94	240,332.26	(15,076.68)
Үндсэн хөрөнгө	1,581,863.36	1,429,461.42	(152,401.94)
Хуримтлагдсан элэгдэл	(1,197,739.68)	(1,192,569.65)	28,455.84
Нийт хөрөнгө	1,838,372.30	2,640,348.79	801,976.50
Өр төлбөр	1,157.95	972,889.83	971,731.88
Засгийн газрын хувь оролцоо	1,837,214.34	1,667,458.96	(169,755.38)
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,838,372.30	2,640,348.79	801,976.50

Тус байгууллага мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлийг төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Авлагын дансны үлдэгдэл 969,455.1 мянган төгрөгөөр өссөн нь авлагын эхний үлдэгдэл 1,100.0 мянга, МЭЕГ-аас тайлант оны дутуу санхүүжилт болох 461,067.3 мянга, орон нутгаас мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 499,109.6 мянга, ҮЭ-ийн авлага 13.8 мянган төгрөгийн үлдэгдэл нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 240,332.3 мянган төгрөг болж оны эхний үлдэгдлээс 15,076.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн болон орон нутгийн хөрөнгөөр 676,244.8 мянган төгрөгөөр бараа материал худалдан авч, 865,333.9 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч, 945.8 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд нийт 1,557,601.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,429,461.4 мянган төгрөг болж оны эхний үлдэгдэл хөрөнгөөс 152,401.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 4,000.0 мянган төгрөгөөр тавилга эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авч, ТӨБЗГ-ын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 200 дугаар тогтоол, МЭЕГ болон Дэлхийн зөн ОУБ-аас 34,333.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлэн авч, 222,793.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан ба ТӨБЗГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 36 дугаар тогтоолоор 373,712.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлж, ТӨБЗГ-ын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 45 дугаар тогтоолоор 44,985.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Байгууллагын программ хангамжид бүртгэлтэй 2,280.0 мянган төгрөгийн өртөг бүхий Хас эрин орчил ХХК-ийн "Dynamic" программыг урсгал зардлын төсвөөс 660.0 мянган төгрөгөөр ашиглах эрх худалдан авч, өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тайлант онд өглөгийн дансны үлдэгдэл 972,889.8 мянган төгрөг болж 971,731.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үүссэн санхүүжилтийн авлагатай холбоотойгоор үүсэн мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 813,217.0 мянган төгрөг,

Биокомбинат ХХК-аас нийлүүлсэн вакцины өглөг 146,595.8 мянган төгрөг болон байгууллагад төлөх 13,077.0 мянган төгрөгийн өр төлбөр нөлөөлжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,632,393.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 2,500.0 мянган төгрөгөөр, урсгал зардлын дүнг 2,634,893.2 мянган төгрөгөөр тооцож дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 2,110,783.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 2,500.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,978,563.9 мянган төгрөг, өөрийн орлогоор 5,181.5 мянган төгрөг төвлөрүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 1,959,140.9 мянган төгрөгийг зарцуулж, 24,604.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,959,140.9 мянган төгрөг буюу нийт батлагдсан төсвийн 92.7 хувийг зарцуулсан байгаа нь тайлант онд бруцеллөз өвчин болон идэвхгүй тандалтын санхүүжилт болох 124,296.7 мянган төгрөгийн хуваарь батлагдсан боловч санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70801 Мал аж ахуйг хөгжүүлэх</b>					
1	82506 Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	16,346.9	-	16.3	-
2	82548 Мал амьтан эрүүлжүүлэх	131,622.4	22,850.1	108.8	0.0
<b>70805 Хөдөө, аж ахуй, газар тариалан</b>					
3	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	1,917,252.0	1,896,151.6	21.1	0.1
4	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	48,061.9	40,139.2	7.9	0.1
<b>Нийт</b>		<b>2,113,283.2</b>	<b>1,959,140.9</b>	<b>154.1</b>	<b>-</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/17 дугаар тушаалыг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-н өдрийн А/02 дугаар тушаалаар байгууллагын бүтэц орон тоог захиргаа санхүүгийн албанд 9, мал, амьтны эрүүл мэндийн албанд 6, мал эмнэлгийн лабораторид 5, сумдын мал эмнэлгийн тасагт 40 нийт 60 орон тоотойгоор

баталсан бөгөөд Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2025 оны А/342 дугаар тушаалын дагуу бүтэц орон тоог шинэчлэн, байгууллагын даргын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн А/47 дугаар тушаалаар гүйцэтгэх 3, үйлчлэх 1 нийт 4 орон тоогоор бууруулж, нийт 56 орон тоотой ажиллахаар тогтоожээ.

2025 онд байгууллагын хоол, унааны хөнгөлөлтөд улсын төсвөөс 72,741.1 мянган төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 81,487.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Тус хөнгөлөлтийг Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын хавсралтын 8.4 дэх хэсэг, байгууллагын хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсгийг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/10 дугаар тушаалаар мал эмнэлгийн төвд ажиллаж байгаа албан хаагчдад хоолны хөнгөлөлтийн хэмжээг нэг өдрийн 10.0 мянган төгрөг байхаар тогтоосон байна.

### 3.5.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд улсын төсвөөс 547,664.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 1,052,047.0 мянган төгрөг, Шинэжинст сумын мал эмнэлгийн тасгийн албан хаагчийн орон нутагт ажилласны нэмэгдэл хөлс 2,077.6 мянган төгрөг төвлөрснийг бүрэн зарцуулсан байна.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар 1,673,806.9 мянган төгрөгийн 6 төрлийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авахаар баталснаас 1,598,892.2 мянган төгрөгийн 5 гэрээ байгуулж, гүйцэтгэлээр 1,090,058.3 мянган төгрөг зарцуулжээ.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны нийт батлагдсан төсөв болох 2,237,949.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 33,569.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Аудитыг төлөвлөх үе шатанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хязгаарлалттай холбоотой 55 заалтыг сонгон шалгасан бөгөөд зөрчил илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаcт мэдээлбэл зохих мэдээллүүдийг хугацаанд нь бүрэн оруулсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1** Завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2** Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

2024 оны санхүүгийн тайлангийн аудитыг Төрийн аудитын байгууллагын аудитор Д.Даваадорж гүйцэтгэсэн бөгөөд аудитаар 7,200.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,432.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг хугацаанд нь бүрэн биелсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	7,200.0	1	7,200.0	100
Албан шаардлага	2	1,432.2	2	1,432.2	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>8,632.2</b>	<b>3</b>	<b>8,632.2</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаашид төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн хуваарилалт, өр төлбөрийн удирдлагад эрсдэл үүсэх магадлалтай тул өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажилласан байдал, төсвийн тодотгол хийх үеийн өр төлбөрийн тооцоонд анхаарч, дараагийн аудитаар давтагдсан эсэхийг үзэх шаардлагатай.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 352,349.8 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

- 2025 онд мал эмнэлгийн аж ахуйн нэгжүүдэд дутуу олгосон мал эмнэлгийн үйлчилгээний хөлс 352,149.8 мянган төгрөг болон Авто доктор хишиг ХХК-руу дутуу шилжүүлсэн 200.0 мянган төгрөгийн автомашины сэлбэгийн үнийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байна.

Энэ нь УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4 дэх "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал тусгана", 14.4.3 дахь "бүх өр төлбөр", 15 дугаар зүйлийн 15.2 дахь "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтад нийцэхгүй байна

Аудитаар нийт 606.0 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 606.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь материаллаг байдлын түвшингээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант онд "Бог малын мялзан өвчний ийлдэс судлалын халдварт түвшин тогтоох" болон "Шимэгдэх өвчний өнөөгийн нөхцөл байдал" сэдэвт хэлэлцүүлэгт оролцох ажлаар албан томилолтоор ажилласан албан хаагчдад олгосон томилолтын олговроос зам хоногийг хасаж тооцоогүй, 606.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь "Хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 дэх "Үнэн зөв байх", Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн 6 дугаар тогтоолын хавсралтын 2.4 дэх "Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно", Мал эмнэлгийн газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/32 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 14.7 дахь заалт "Албан хаагчдад томилолтын зардлыг олгохдоо Засгийн газрын тогтоосон тариф, шийдвэрийн үндэслэн тогтооно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцсон томилолтын олговор 606.0 мянган төгрөгийг албан хаагчаар буцаан төлүүлж, биелэлтийг нотлох баримтын хамт 2026 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар томилсон эд хөрөнгийн тооллогын комисс жилийн эцсийн эд хөрөнгийг 80,782.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тоолж, тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болох орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 7.4 дэх "Тооллогын комисс дараах үүрэгтэй", 7.4.1 дэх "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах" гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгийн тооллогыг дахин явуулж дүнг үнэн зөв баталгаажуулах, нотлох баримтыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд “Бог малын мялзан өвчний ийлдэс судлалын халдварт түвшин тогтоох” болон “Шимэгдэх өвчний өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт хэлэлцүүлэгт оролцох ажлаар албан томилолтоор ажилласан албан хаагчдад олгосон томилолтын олговроос зам хоногийг хасаж тооцоогүй, 606.0 мянган төгрөг илүү шилжүүлсэн байна	1	606.0	1	606.0				
Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар томилсон эд хөрөнгийн тооллогын комисс жилийн эцсийн эд хөрөнгийг зөрүүтэй тоолж, тайлагнасан байна.	1	-			1	-		
Дүн	2	606.0	1	606.0	1	-		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----